



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/631

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны арвантавдугаар хуралдааны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цэнхэрмандал сумын ерөнхий боловсролын сургуулийн дуу хөгжмийн кабинетэд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах зардалд зориулан 6,000,000 (зургаан сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралтаар баталсугай

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Шаардлагатай сургуулиудын орчин нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжөөр хангана” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 13-ны  
12/631 дугаар захирамжийн хавсралт

### ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	Тоног төхөөрөмж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	JBL srx 725	2	1,500,000	3,000,000
2	Shura beta a58 зайны мик	1	650,000	650,000
3	Microphone хөл	4	140,000	560,000
4	HD4800W 4 сувагт чадал	1	1,650,000	1,650,000
5	Shure sm58 microphone	2	70,000	140,000
<b>Нийт дүн</b>				<b>6,000,000</b>